

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 12 сарын 07 өдөр

Дугаар 348

Улаанбаатар хот

“Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх,
зарцуулах, түүнд хяналт тавих журам”-д
нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.3, 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 232 дугаар тогтоолоор батлагдсан “Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-д дор дурьдсан агуулгатай 5.4, 6.3 дахь заалтыг тус тус нэмсүгэй:

1/ “5.4. Тайлант улирлаас өмнө гарсан даатгалын тохиолдлын улмаас даатгуулагчаас нэхэмжлэл ирсэн тохиолдолд учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сангаас нэхэмжилсэн хохирлын нөөц санг байгуулна”,

2/ “6.3. Энэхүү журмын 6.2-т заасан олгохоор тооцсон нөхөн төлбөрийг тайлант хугацаанд хүчинтэй байгаа гэрээнүүдээс нэхэмжилж болзошгүй хохирлын хэмжээ гэж ойлгоно. Олгохоор тооцсон нөхөн төлбөрийг тооцоолохдоо бодит мэдээлэлд үндэслэн актуар аргачлалаар улирал бүр тооцно.” гэж,

2. “Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 4.2, 4.3, 5.3 дахь заалтыг дор дурьдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

1/ “4.2. Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц санг даатгалын тохиолдол нь тайлант улирлаас өмнөх үед учирсан бөгөөд тайлант улиралд нэхэмжилж болзошгүй нөхөн төлбөрийг барагдуулахад зориулан байгуулна. Уг нөөц санг өмнөх хугацааны даатгалын нөхөн төлбөрийн бодит мэдээлэлд үндэслэн актуар тооцооллоор тооцож, орлогод тооцсон хураамжаас улирал бүр байгуулна,

4.3. Тайлант улирлаас өмнө гарсан даатгалын тохиолдлын улмаас гэрээний дагуу даатгуулагчаас нэхэмжлэл ирсэн тохиолдолд даатгуулагчийн нэхэмжилсэн дүнгээр уг нөөц сангаас нэхэмжилсэн хохирлын нөөц сан руу шилжүүлнэ.” гэж.

2/ “5.3. Тайлант улиралд гарсан даатгалын тохиолдлын дагуу даатгуулагчаас нэхэмжлэл ирсэн тохиолдолд орлогод тооцсон хураамжаас нэхэмжилсэн хохирлын нөөц санг байгуулна.” гэж

3. Хорооны 2009 оны 232 дугаар тогтоолын 4 дэх хэсэгт заасан тусгайлсан нөөц сангийн 2011 оны эцсийн үлдэгдлийг учирч болзошгүй хохирлын нөөц сангийн 2012 оны эхний үлдэгдэл дээр нэмж тооцон, тусгайлсан нөөц санг 2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хааж ажиллахыг даатгалын компаниудад үүрэг болгосугай.

4. Журамд нэмэлт, өөрчлөлтийг оруулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газарт тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН